



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/440

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "А" дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор хэрэгжүүлж буй иргэдийг соён гэгээрүүлэх, түүний дотор залуучуудад зөв ухамсар, хүмүүжлийг төлөвшүүлэх зорилготой "Хайртай" төслийг орон нутагт хэрэгжүүлэх, зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Даваадорж -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Ч.Багдал -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Ц.Ганданповрон -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого Төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Н.Ганзориг -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Ганхуяг - Аймгийн Цэргийн штабын дарга, дэд хурандаа

С.Ариунжаргал -Аймгийн Хөгжимт драмын театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга: Б.Гомбосүрэн -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

2. Төсөл хэрэгжүүлэгч бүрэлдэхүүнийг аймагт ажиллах хугацаанд аюулгүй байдлыг зохих түвшинд хангаж, байрлах байр, хоол, хүний нөөц бусад чиглэлээр дэмжлэг үзүүлж, орон нутагт өндөр түвшинд зохион байгуулж хамтран ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/440 Ch
02 02195